

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2020 ОНД АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 14


Улаанбаатар хот


№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Хэрэгжилтийн биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
Нэг. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн ажлын хүрээнд				
1.	Амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах	1. Ажилтан, албан хаагчдын газар өмчлөл болон орон сууцны судалгааг шинэчлэн гаргаж, хүсэлт гаргаж, хүсэлт гаргасан албан хаагчдын ажилласан хугацаа, ажлын үр дүнг харгалзан орон сууц, хашаа худалдан авах, амьдрах орчин нөхцөлөө сайжруулахтай холбоотойгоор хөнгөлөлттэй зээлд хамрагдахад байгууллагаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх	Тайлант онд тус газар нь нийт ажилтан, албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийн судалгааг шинэчлэн нэгтгэж, улмаар НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус газрын 80 гаруй хувь нь гэр хороололд амьдардаг болохыг уламжилж төрийн албан хаагчдын амьдрах орчинг сайжруулж амьдралын баталгаа, ажлын тогтвор суурьшлыг хангах зорилгоор хэрэгжүүлж буй түрээслээд өмчлөх хэлбэрээр оронсууцжуулах төсөлд хамруулж дэмжлэг үзүүлэх хүсэлтийг гаргасан. Энэ хүрээнд НЗДаргаас 5 квотыг олгосноор ННҮГазарт олон жил үр бүтээлтэй ажилласан байр хариуцсан менежер М.Мөнхцэцэг, слесарь О.Лхамсүрэн, үйлчлэгч Ц.Энхжаргал, Н.Саранцэцэг, тогооч Б.Оюун-Эрдэнэ нарын 5 хүнийг удирдлагын зөвлөл нийт ажилтан, албан хаагчидтай хамтран нээлттэйгээр хуралдан хэлэлцэж шийдвэрлэсэнээр тус орон сууцанд хамрагдсан.	100
		2. Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс олгох, авахад нь тусламж дэмжлэг үзүүлэх	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг 32 ажилтанд түлээ, нүүрс авахад нь хөнгөлөлт, тусламж үзүүлсэн. Үүнд нийт 6.400.000 төгрөгийг зарцуулсан.	100
		3. Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтан, албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгох	Тайлант хугацаанд байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарч буй 19 ажилтан, албан хаагчид Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолыг үндэслэн нийт 282.680.245 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон.	100
2.	Төрийн албан хаагчид үзүүлэх тусламж, тэтгэмж	1. Ажилтны гэр бүлийн хөдөлмөр эрхлэх насны ажил идэвхтэй хайгч гишүүнийг хөдөлмөр зуучлалын газраар зуучлуулж, ажил хөдөлмөр эрхлэхэд нь туслах	Тайлант хугацаанд ажилтны гэр бүлийн хөдөлмөр эрхлэх насны ажил хайгч 2 гишүүнийг хөдөлмөр зуучлалын газраар зуучлуулан, ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангасан.	100
		2. Орон байр нь гал, усны үер, газар хөдлөлт зэрэг байгалийн болон гэнэтийн давагдашгүй аюулд өртөж хохирол учирсан албан хаагчид мөнгөн тусламж үзүүлэх	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын орон байр нь гал, усны үер, газар хөдлөлт зэрэг байгалийн болон гэнэтийн давагдашгүй аюулд өртөж хохирол учирсан тохиолдол гараагүй болно. Нийслэлийн Онцгой комиссын 07 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын А/342, А/590 дүгээр захирамжийг тус тус үндэслэн эргүүлээр идэвх санаачлагатай ажилласан ажилтан, албан хаагчдад 72.133.520 төгрөгний мөнгөн урамшуулал олгосон.	100

1	2	3	4	5
		3. Өөрийн ажилтан албан хаагч болон ажилтны гэр бүлийн гишүүн / нөхөр, эхнэр, төрсөн эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү болон хадам эцэг, эх, эмээ, өвөө / нас барсан тохиолдолд буяны ажилд нь болон ажилтан гадаад улсад эмчлүүлснийг нотлох баримтыг үндэслэн эмчилгээний зардалд буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх	Тайлант хугацаанд байгууллагын дотоод журмын 6.10, 6.10.1, 6.10.2-т заасны дагуу 36 ажилтан, албан хаагчдад байгууллагад гаргасан өргөдлийг үндэслэн 11.856.727 төгрөгний буцалтгүй мөнгөн тусламжийг үзүүлсэн.	100
Хоёр. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд				
1.	Амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах	1. Албан хаагчдад шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	Тайлант онд албан хаагчдын шаардлагатай 5 төрлийн техник, тоног төхөөрөмжөөр /16.126.000 төгрөг/ ханган ажилласан.	100
		2. Ажилтан, албан хаагчдад ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн зардал болон өдрийн хоолны мөнгөний зохих хэсгийг олгох	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын тээврийн зардалд 30.239.500 төгрөг, өдрийн хоолны зардалд 242.004.000 төгрөгийг тус тус олгон ажилласан байна.	100
		3. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэхээр суралцах үед ажлаас түр чөлөөлөх, эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлсийг олгох	Тайлант хугацаанд өөрийн мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэн суралцаж буй 8 албан хаагчийг байгууллагын зүгээс суралцах нөхцөл боломжийг нь бүрдүүлж, албан тушаалын цалин хөлсийг бүтэн олгож дэмжлэг үзүүлэн ажилласан.	100
2.	Цалин хөлс, шагнал урамшуулал	1. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн үнэлж, урамшуулал олгох	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", тус газрын "Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам"-ын дагуу 2020 онд нийт давхардсан тоогоор 327 ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийг үр дүнг улирал бүр үнэлж, 272.663.426 төгрөгний урамшуулал олгон ажилласан.	100
		2. Ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмж, ур чадварыг сар бүр дүгнэж, ур чадварын нэмэгдлийг тооцож олгох	Тайлант хугацаанд газрын даргын 2020 оны А/24, А/38, А/52 дугаар тушаалуудаар ажилтан, албан хаагчдын 2020 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын ур чадварыг дүгнэж Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгосон. Тухайн жилд нийт 329.843.861 төгрөгийг ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдэлд олгосон байна.	100
		3. Ажилдаа идэвх зүтгэл гаргаж, өндөр амжилт гаргасан ажилтан, албан хаагчийг төрийн одон медаль болон бусад шагналд тодорхойлох, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулах	Тайлант хугацаанд эрхэлсэн ажилдаа идэвх санаачилга гарган ажиллаж буй 41 ажилтан, албан хаагчийн хөдөлмөрийг үнэлж төрийн Засгийн газрын шагнал болон бусад шагналд тодорхойлсон. Үүнд: - МУ-ын Засгийн газрын шагнал Барилга, хот байгуулалтын яамны "Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан" цол тэмдгээр 4; - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны "Үйлдвэр, худалдаа үйлчилгээний тэргүүний ажилтан" цол тэмдгээр 2, "Жуух бичиг"-ээр 1; - Монголын Залуучуудын холбооны шагналаар 11;	100

1	2	3	4	5
2.	Цалин хөлс, шагнал урамшуулал		<p>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагнал “Хүндэт үнэмлэх”-ээр 7; - НЗД-ын “Нийслэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр 4; - НЗД-ын “Жуух бичиг”-ээр 12 тус тус шагнагдсан.</p>	
		4. Ажлын зайлшгүй шаардлагын улмаас ээлжийн амралтаа биеэр эдлэж чадаагүй ажилтанд нөхөн олговорыг олгох	Газрын даргын 2020 оны 03 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу 251 ажилтан, албан хаагчдад ээлжийн амралтыг биеэр нь эдлүүлсэн.	100
		5. Илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу тухай бүр шийдвэрлэх	Тайлант хугацаанд илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу 36 ажилтан, албан хаагчид нийт 63.225.624 төгрөгний нэмэгдэл хөлсийг тухай бүр олгож ажилласан.	100
		6. Ажилтан, албан хаагчдад төрийн байгууллагад ажилласан жилийн хугацааны нэмэгдлийг тооцож олгох	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу 273 ажилтан, албан хаагчийг төрийн албанд ажилласан жилийн судалгааг гарган төрийн байгууллагад ажилласан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгон ажиллаж байна.	100
3.	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах	1. Ажилтнуудыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	<p>Тайлант онд цар тахалтай холбоотойгоор эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгийг зохион байгуулагдаагүй болно. Цаг үеийн нөхцөл байдалд тохируулан Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Амны хаалт-Таны баталгаа” чөллөнж хөдөлгөөнийг өрнүүлэн олон нийтийн сүлжээгээр ажилтан, албан хаагч болон иргэд олон нийтийг уриалан ажилласан. Мөн ажилтан, албан хаагчдыг коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих зорилгоор ажилтан, албан хаагчдад витаминжуулалтын аян зохион байгуулсан.</p> <p>Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын нийт ажилтан, албан хаагчдыг өөрийн оршин суух дүүрэг, хорооны харьяаллын дагуу коронавирусийн PCR шинжилгээнд хамрагдах үүрэг, чиглэл өгсөн бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар 277 ажилтан, албан хаагчид шинжилгээнд бүрэн хамрагдаад байна.</p>	100
		2. Ажилтан, албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардлын тодорхой хэсгийг олгож дэмжлэг үзүүлэх	<p>Ажилчдын ХАБЭА-н мэдлэгийг нэмэгдүүлэх, дадал хэвшлийг болгох үүднээс дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн” зааварчилгааг байр тус бүрийн онцлог, нөхцөл байдалд тохируулан бэлтгэн онол, дадлага хэлбэрээр 167 ажилтан; - Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-ын тэргүүн Н.Баасанжавыг урин ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, төхөөрөмжийг хэрхэн ашиглаж хэрэглэх, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр “Коронавирус халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт сургалтад ажилтан, албан хаагч – 35; - Мэргэшсэн инженер, магистр багш Б.Бямбацэрэнг 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр урин “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт 	100

1	2	3	4	5
3.	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах	3. Цасны баяр, явган болон тойрон аяллыг Биеийн тамир, спорт хамтлагийн ажлын төлөвлөгөө, батлагдсан удирдамжийн дагуу жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах	<p>сургалтад ашиглалтын албаны 30 ажилтанд тус тус сургалт зохион байгуулан ажилласан.</p> <p>Мөн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага" стандартыг шинэчлэн боловсруулж, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газраар хянуулан 2 байгууллагын зөвшилцсөнөөр газрын даргын тушаалаар баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гэмтэл бэртэл авсан, эрүүл мэндээр хохирсон тохиолдол гараагүй болно.</p> <p>Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойн баярын тохиолдуулан байгууллагаас ажилтан, албан хаагчдын дунд спортын наадмыг 2020 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, ширээний теннис гэсэн 4 төрлөөр амжилттай зохион байгууллаа. Спортын наадамд байгууллагын 9 баг 80 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, Г.Батзаяа ахлагчтай "Galaxy" баг эзэлж "ШИЛЖИН ЯВАХ ЦОМ"-ын эзэн болсон бөгөөд 2 дугаар байрт Б.Хэнмэдэх ахлагчтай "Фирари" баг, 3 дугаар байрт Галмандах ахлагчтай "Нэрээ бодоорой" баг тус тус шалгарсан.</p>	100
Дундаж хувь:			100%	

ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА  Ч.ШИНЭЧИМЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ
 ХАРИУЦСАН АЖИЛТАН  У.ҮРЭЛМАА